

5

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ОРНУУДЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

Д.Дагвадорж, Ц.Цолмон, Н.Батнасан


Оршил

“ЗҮҮН ХОЙД АЗИЙН ОРНУУДЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА” сэдэвт эрдэм шинжилгээний төсөлт ажлыг МУИС-ийн Азийн судалганы төвийн санхүүжилтээр маркетинг-олон улсын худалдааны тэнхимийн профессор багш нар сүүлийн нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэв. Энэ ажлын хүрээнд ЗХА-ийн бүс нутгийн орнуудын хэрэглээний барааны зах зээлийн хөгжлийн гол хандлагыг тогтоож, бүс нутгийн орнуудын зах зээлийг өөр хооронд нь нээлттэй, чөлөөтэй байлгах арга замыг боловсруулах, улмаар Монгол улсаас энэ бүс нутгийн орнуудад бараа экспортлох боломжийг нэмэгдүүлэх, мөн импортын оновчтой болгох боломж арга замыг тодорхойлох зорилгыг тавьж холбогдох судалгааг хийн зарим үр дүнд хүрсэн юм.

I. Зүүн орнуудын эдийн засаг – зах зээлийн харилцааны хөгжлийн шинэ үе

Зүүн Хойд Азийн бүс нутгийн хэрэглээний зах зээлд Монгол, Япон, Өмнөд, Хойт Солонгос,, Хятадын Зүүн Хойт нутаг, ОХУ-ын Баруун Сибирийн хэсэг багтах бөгөөд нийт зах зээлд 1.7 тэрбум гаруй хүн ам хамаарагдаж байна. Үүнийг газрын зурагт тусган илэрхийлбэл:

1-р зураг



Хөгжиж буй дэлхий ертөнцөд Зүүн Хойт Азийн орнуудын эзлэх байр суурь сүүлийн 15 жилд өсөн нэмэгдсээр ирсэнийг, Монголыг оролцуулах энэ бүс нутгийн голлох орнууд хөгжлийн хурдаараа манлайлж байгааг 1-р хүснэгтээс харж болно.

1-р хүснэгт

Дэлхийн улс орнуудын ДНБ-ий өсөлт

	1990-2000	1998	1999	2000	2001	2002	2003	2004
Дэлхий	2.3	2.2	3.0	4.0	1.4	1.7	2.6	3.8
Хөгжингүй орнууд	2.4	2.5	2.9	3.5	1.0	1.2	2.0	3.2
АНУ	3.5	4.2	4.4	3.7	0.5	2.2	3.1	4.0
ЕХ	2.1	2.9	2.9	3.6	1.7	1.0	0.7	2.0
Япон	1.4	-1.1	0.1	2.8	0.4	-0.3	2.5	4.3
Хөгжиж буй орнууд	4.9	1.3	3.6	5.6	2.4	3.5	4.5	5.8
Ази	6.2	0.7	5.4	6.9	3.2	5.4	5.9	6.6
БНХАУ	10.3	7.8	7.1	8.0	7.5	8.0	9.1	8.5
БНСУ	5.8	-6.7	10.9	9.3	3.1	6.4	3.1	6.5
Шилжилтийн эдийн засагтай орнууд	2.5	-0.8	3.6	6.8	4.5	3.9	5.9	5.9
ОХУ	-4.7	-5.3	6.4	10.0	5.0	4.3	7.3	7.0
Монгол	0.0	3.5	3.2	1.1	1.0	4.0	5.5	10.6

Эх сурвалж: World Bank "World Development Indicators-2004"

Эдийн засгийн өсөлтийн хурдац өндөр байгаа явдал өнөөгийн Зүүн Хойд Ази нь зөрчил, мөргөлдөөн, үл итгэх байдлыг даван туулж

чадвал ирээдүйд дэлхийн эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг болох чадамжтай юм

Энэ бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааг шинэ төвшинд гарган хөгжүүлэхэд эрдэмтэн судлаачдын зүгээс тэгээр орнуудын хөгжлийн амин чухал асуудал болох зах зээл, худалдаа эдийн засгийн харилцааг бодит тоо баримтуудад тулгуурлан шинжлэн судлах асуудал үлэмж ач холбогдолтой юм. Бидний судалгаа чухамхүү энэ асуудалд чиглэгдэж байна.

II. Зүүн Хойт Азийн орнуудын хэрэглэгчдийн зах зээл

Хэрэглээний зах зээлийн байдал төлөвийг харуулах хүн амын тоо, хүн амын нягтрал, суурьшил, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ зэрэг нь Зүүн Хойт Азийн орнуудад харилцан адилгүй төвшинд байна. Зүүн Хойд Азийн бүс нутгийн нэг хүнд ногдох орлогын хэмжээ харилцан адилгүй төвшинд байна. Бүс нутгийн хамгийн бага орлого бүхий Монгол улсад нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 457 ам.долларын хэмжээнд байгаа бол энэ үзүүлэлт Хятадад 780 ам.доллар, Өмнөд Солонгост 10006 ам.доллар, Японд 31407 ам.доллар байгаа юм.⁴ /Human Development Report 2004/.

ЗХА-ын орнуудын зах зээлийг бүрдүүлж буй хүн амынх нь тоо, насны бүтцийг 2-р хүснэгтээр авч үзэв.

Хятадын хүн амын өсөлтийн түвшин 0.57, Япон 0.08, Хойд Солонгос 0.98, Өмнөд Солонгос 0.62 байхад Монгол улсад 1.43 гэсэн үзүүлэлтэй буюу өсөлтийн хурд хамгийн өндөр байна.

2-р хүснэгт

ЗХА-ын орнуудын хүн амын насны бүтэц /2004 оны байдлаар, дүнд эзлэх хувиар/

	Хятад	Япон	Хойд Солонгос	Өмнөд Солонгос	Монгол	ОХУ
Нийт хүн ам	1298847.624	127333002	22697553	48598175	2751314	6000000
Насны бүтэц, %						
0-14:	22.3	14.3	24.6	20.4	32.6	15.0
15-64:	70.3	66.7	67.8	71.4	63.8	71.3
65-аас дээш	7.5	19	7.6	8.2	3.6	13.7

Эх сурвалж: The world factbook 2004.

Зүүн Хойд Азийн орнуудын хүн амын насны бүтцийн байдлыг авч үзвэл 0-14 насны хүн амын тоогоор Монгол улс хамгийн өндөр буюу

⁴ Human Development Report 2004

29.7 хувийг, 15-64 насны хүн амын хувьд Өмнөд Солонгос 71.4 хувь, харин 65 дээш насны хүн амын хувьд Япон 19 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Эндээс үзвэл Япон улс нийт хүн амын дотор өндөр настай хүний эзлэх хувиараа, Монгол улс хүүхдийн эзлэх хувиараа хамгийн өндөр байгаа нь харагдаж байна.

ЗХА-ийн орнуудын хэрэглээний зах зээл, худалдан авагчийн зан төлөвийн гүнзгийрүүлсэн судалгааг хийх нь эдгээр орны хэрэглээний зах зээлийн ерөнхий төлөв байдал, хэрэглэгчийн зан төлөвийн хэтийн хандлагыг тогтооход нэн чухал ач холбогдолтой юм.

Хятад, Өмнөд Солонгос, Японы хэрэглэгчдийн өнгөнд хандах зан төлөвийн харьцуулсан судалгаа хийж улмаар ЗХА-ын томоохон орнууд болох Япон, Хятад, Өмнөд Солонгосын хэрэглэгчдийн зан төлөвт гарч байгаа өөрчлөлтийг орон тус бүрээр дэлгэрэнгүй шинжилж үзсэн юм.

Энэ хэсгийн судалгаанаас дараах ерөнхий дүгнэлт гарч байна. Үүнд:

1. ЗХА-ын хэрэглэгчдийн зах зээлд сегментийн ялгаа гүнзгийрч өвөрмөц сегментүүдийг илрүүлэн олж нэвтрэх нь энэ бүс нутгийн зах зээлд амжилт олох чухал сэжиг болж байна.
2. Даяаршлын үйл явцтай уялдан Азийн хэрэглэгчид, ялангуяа залуучууд барууны хэв маягийг дууриах нь түгээмэл шинжтэй болж байна.
3. Гэхдээ орон тус бүрийн түүхэн хөгжил, өвөрмөц хэв маягаас үүдэн зан төлөвийн ялгаатай хэв загварууд илэрч буй бөгөөд тэр бүгдийг тооцож олон улсын маркетингийн стратеги бодлогодоо тусгах шаардлага зах зээлийн харилцааны туршлага багатай Монгол орны хувьд нэн чухал юм.

III. Зүүн Хойт Азийн орнуудын худалдааны өсөлт

Зүүн Хойт Азийн бүс нутгийн орнууд дэлхийн нийлбэр ДНБ-ий 1/5-ийг үйлдвэрлэж байгаа бол Япон улсын ДНБ дангаараа дэлхийн нийлбэр ДНБ-ий 1/7-ийг үйлдвэрлэж байна.⁵

2003 онд дэлхийн нийт экспорт 12.7%, импорт 12.9%-иар өссөн бол Зүүн Хойд Азийн орнуудын экспорт 22.5%, импорт 27.6%-иар тус тус өсчээ. Дэлхийн нийт экспортод 17.0%, нийт импортод 14.3%-ийг эзэлдэг энэ бүс нутагт экспортын өсөлтийн 27.8%, импортын

⁵ WB World Development Indicators

өсөлтийн 27.0% нь ногдож байна.⁶ Ялангуяа Хятадын гадаад худалдааны өсөлт дэлхийн худалдааны өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэх болжээ.

Эдийн засаг, худалдааны өсөлт нь энэ бүс нутгийн орнуудын зах зээлийг дэлхийн зах зээлийн анхаарал татахуйц сегмент болгон хувиргаж, энэ бүс нутгийн гүйцэтгэх үүрэг роль улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай болов.

ЗХА-ын бүс нутгийн эдийн засгийн түргэн хурдацтай өсөлт экспортлогчдод шинэ шинэ боломжуудыг нээж байгаа бөгөөд үүнээс улбаатайгаар дэлхийн олон улс орон энэ бүс нутаг уруу чиглэсэн худалдааны бодлого, хөтөлбөр боловсруулан ажиллах болсон.


Энэ бүс нутагт барааны экспорт, импортын бодит хэмжээ сүүлийн 15 жилд дундажаар 10 орчим хувиар нэмэгдсэн нь дэлхийн дунджаас бараг 2 дахин илүү байна. Барааны экспортын хэмжээ 17% орчим нэмэгдсэн нь дэлхийн дунджаас бас л өндөр байгаа боловч зарим бүс нутгуудтай харьцуулахад доогуур байгаа юм. ЗХА-ын голлох орнуудын барааны ч, үйлчилгээний ч худалдаа дэлхийн дундажаас илүү хурдацтайгаар өсөн нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь бүс нутгийн зах зээлийн өргөжилтийн эрчимийг илэрхийлж буй чухал үзүүлэлт юм.

Зүүн Хойд Азийн бүс нутгийн орнуудын экспорт нь ерөнхийдөө АНУ, Европын холбоо, Япон зэрэг эдийн засаг, техник, технологийн өндөр хөгжилтэй бүс нутаг уруу чиглэж байгаа нь энэ бүс нутагт үйлдвэрлэж буй таваар нь олон улсын зах зээлд хүчтэй өрсөлдөх хэмжээнд хүрч чадсаныг харуулж байна.

Бүс нутгийн орнуудын экспортын өсөлтийг графикаар илэрхийлбэл дараах байдалтай байна.

⁶ WTO "World Trade Statistics-2004" –т тулгуурлан төслийн багийн судлаач, док. Н.Батнасангийн хийсэн тооцоо

1-р график




Сүүлийн жилүүдэд нутгийн орнуудын худалдааны урсгал нь Хятад уруу чиглэх болов. Энэ нь Хятад улс ДХБ-д элсэн, сүүлийн жилүүдэд Хятадын эдийн засаг өндөр хурдацтайгаар өсч байгаа зэрэгтэй шууд холбоотой юм.

Зүүн Хойд Азийн бүс нутгийн орнуудын импортод техник технологийн өндөр хөгжилтэй АНУ, Япон, ЕХ-ны орнууд томоохон байр суурийг эзэлж байгаа нь энэ бүс нутгийн эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлж байж болзошгүй юм.

Импортын өсөлтийг графикаар илэрхийлбэл дараах байдалтай байна.

2-р график



Бүс нутгийн улс орнуудаас Азийн орнуудтай хийх худалдааны хувийн жин өсөх хандлагатай байгааг судалгааны тоо баримтууд нотолж байна. Манай хоёр хөрш ОХУ-БНХАУ-ын эдийн засгийн гадаад харилцаа сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байгаа бөгөөд энэ хандлага ойрын жилүүдэд хадгалагдаж 2010 он гэхэд худалдааны нийт эргэлт 20 тэрбум долларт хүрэх юм.

3-р хүснэгт

Зүүн Хойд Азийн орнуудын барааны худалдааны бүтэц

	Экспортын бүтэц				Импортын бүтэц			
	Бүгд	ХАА	Олборлох үйлдвэрлэл	Аж үйлдвэр	Бүгд	ХАА	Олборлох үйлдвэрлэл	Аж үйлдвэр
БНХАУ	100.0	5.8	4.2	89.9	100.0	7.4	11.8	80.2
Хонгконг	100.0	2.4	1.3	94.9	100.0	5.2	3.7	90.5
Тайвань	100.0	2.6	2.9	93.7	100.0	6.4	15.1	76.5
Япон	100.0	1.1	1.6	93.0	100.0	16.3	24.2	57.5
БНСУ	100.0	2.4	5.3	90.7	100.0	8.8	26.3	61.9
ОХУ	100.0	7.2	64.0	27.3	100.0	19.8	5.2	74.9
Монгол	100.0	5.0	52.3	32.7	100.0	15.8	20.2	64.0

Хүснэгтээс үзвэл, бүс нутгийн зарим орнуудын экспорт, импортын бүтэц өөр хоорондоо төсөөтэй байгаа нь бүс нутгийн худалдааг өргөжүүлэхэд зарим саад бэхшээл үүсгэж байгаа юм. Япон, Өмнөд Солонгос улсуудад, ОХУ, Монгол улсуудад ийм төсөөтэй байдал ажиглагдаж байна.

Бүс нутгийн тэргүүлэгч орнууд болох Япон, Хятад, Солонгос зэрэг улс орнууд экспортод чиглэсэн хөрөнгө оруулалтыг дээд зэргээр урамшуулахын тулд "худалдаагаа либеральчлах бодлого"-ыг эрчимтэй хэрэгжүүлж байна. Нэн ялангуяа технологийн өндөр багтаамжтай бүтээгдэхүүний импортын татварыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч байгаагийн үрээр энэ бүс нутагт хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг нь эд ангийг угсрах үйлдвэрлэлийн салбар, электроникийн салбарт ногдож байна.

Зүүн Хойд Азийн Япон, Солонгос, Хятад зэрэг орнуудын үсрэнгүй хөгжил нь макроэдийн засгийн бодлого, дэд бүтэц, дотоодын зах зээлийн бүтэц, засаг төрийн байгууллага тэдгээрийн бүтэц гэх мэт олон хүчин зүйлсийн нөлөөллийг тооцсон эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшилд нийцэхүйц худалдааны цогцолбор бодлогыг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байгаагийн бодитой жишээ юм.

Бүс нутгийн улс орнуудаас Азийн орнуудтай хийх худалдааны хувийн жин өсөх хандлагатай байгааг судалгааны тоо баримтууд нотолж байна. Манай хоёр хөрш ОХУ-БНХАУ-ын эдийн засгийн гадаад харилцаа сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байгаа бөгөөд энэ хандлага ойрын жилүүдэд хадгалагдаж 2010 он гэхэд худалдааны нийт эргэлт 20 тэрбум долларт хүрэх юм..

ОХУ, БНХАУ хоёрын аль аль нь геополитикийн хувьд Монголыг нөлөөний хүрээндээ байлгах сонирхолтой бөгөөд өнөөгийн нөхцөлд улс орны эдийн засаг эдгээр орноос хамаарах хамаарал ихтэй байна. ОХУ-ын зах зээлд үнэ 1% өсөхөд энэ нь Монголын ДНБ-ийг 0.17%-иар бууруулах, Хятадын зах зээлд үнэ 1% өсөхөд энэ нь Монголын ДНБ-ийг 0.07%-иар нэмэгдүүлэхэд тус тус хүргэдэг гэдгийг бидний судалгааны дүн харуулж байна.⁷

Сүүлийн жилүүдэд Монголд оруулсан хөрөнгө оруулалт нь ажлын байр олноор бий болгодоггүй, гол төлөв байгалийн үл нөхөн сэргээгдэх баялгийг олборлох чиглэлд хийгджээ. Тиймээс эдийн засгийн өсөлтөд дорвитой хувь нэмэр оруулж чадаагүй⁸ байна. 1990-2003 онуудад нэг хүнд ногдох шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 386.8 дахин өссөн⁹ бол ДНБ ердөө л 10.5%-иар өссөн¹⁰ дүн гарчээ.

Ийм учраас гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр ашигтай хослолыг хангасан ЗХА-ын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх шинэ бодлого зайлшгүй болж байгаа юм.

"Түмэн бүс" ЗХА-ын орнуудын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц хэлбэр болох нь. ЗХА-ийн орнуудын бодитойгоор эхэлсэн хамтын ажиллагааны хэлбэр нь "Түмэн гол" төсөл юм. Энэ төслийн хүрээнд хамтран ажиллах хэлэлцээрт БНХАУ, БНАСАУ, МУ, БНСУ гарын үсэг зурснаар хөтөлбөрийн үйл ажиллагааг эхэлсэн бөгөөд 1992 онд ОХУ уг төсөлд нэгдэн орсон юм.

"Түмэн бүс"-д мөн Монголын Дорнод бүсийг хамааруулан авч үзэж байна. "Түмэн бүс" хөтөлбөр (ТБХ) нь Түмэн голоор хил залгаа ОХУ, БНХАУ, БНАСАУ-ын төдийгүй ЗХА-ын орнуудын 21-р зууны хамтын ажиллагааны томоохон төслийн нэг юм.

"Түмэн бүс" хөтөлбөрийг:

-1991-1996 онд

-1996-2001 он

-2001 оноос хойш гэсэн шатлалаар хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд уг төслийн ажилд эхнээс нь идэвхтэй оролцож, Дорнод Монголын бүс нутгийг Түмэн бүстэй холбон хөгжүүлэх чиглэл

⁷ "Монгол улсын статистикийн эмхтгэл", ДБ-ны "World Development Indicators-2004"-т тулгуурлан төслийн багийн судлаач, док. Н.Батнасангийн хийсэн тооцоо

⁸ Н.Батнасан "Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөхцөл байдалд хийсэн шинжилгээ" УБ 2005

⁹ ГХГХОА-ийн мэдээ, "World Investment Report 2004"-т тулгуурлан хийсэн тооцоолол

¹⁰ "Монгол улс зах зээлд" статистикийн эмхтгэл, "Монгол улсын статистикийн эмхтгэл-2003"-т тулгуурлан хийсэн тооцоо

баримтлан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Монголын Дорнод бүсийг Зүүн хойд Хятадаар Түмэн бүс нутагтай холбох авто болон төмөр замын тээврийн сүлжээг бий болгох, Зүүн хойд Азийн бүс нутгийг хамарсан аялал жуулчлал, байгаль орчны цогц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч байна..

Ийнхүү Түмэн бүс хөтөлбөр Монголын зах зээлийг ЗХА-ын орнуудын зах зээлтэй холбох нээлттэй суваг, өвөрмөц хэлбэр болон хөгжих ирээдүйтэй байна.

Зүүн Хойд Азийн бүс нутгийн орон тус бүрийн зах зээл, гадаад худалдаа, Монгол улсын ЗХА-ын зах зээлд нэвтэрсэн туршлага сургамж.

Төсөлт ажлын хүрээнд ЗХА-ын орон тус бүрийн зах зээл гадаад худалдааны байдлыг газар зүйн байршилтай нь уялдуулан экспорт, импортын төрөл тус бүрээр судалсанаас гадна Монгол улс хөрш 2 орон болон Өмнөт Солонгосын зах зээлд ажиллаж ирсэн үйл явцад дүн шинжилгээ хийсэн болно. Эндээс дараах дүгнэлт гарч байна.

Дэлхийн улс орнууд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллаж, харилцан үр ашгийг хүртэх нь эдийн засгийн өсөлтөнд хүргэх гол хүчин зүйл гэдгийг стратегийн зорилгоо болгож гадаад эдийн засгийн бодлого, гадаад зах зээлд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа онцгой ач холбогдол өгч байна.

Монгол улс ч энэ талаар зохих туршлага хуримтлуулж зах зээлийн харьцангуй таатай нөхцөлтэй орнуудад эдийн засгийн харьцангуй давуу ашиглаж гадаад худалдаагаа өргөжүүлж ирсэн нь судалгаанд хамрагдсан орнуудтай хийсэн худалдааны эрэглтийн өсөлт, гадаад худалдааны түнш орнуудын өөрчлөлт хувьсал, экспорт, импортын бүтцийн судалгаа харуулж байна.

4-р хүснэгт

Монгол улсын гадаад худалдааны түншийн өөрчлөлт, хувьсал

Он	1990	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
I байр	ЗХУ	ОХУ	ОХУ	Хятад	Хятад	Хятад	Хятад	Хятад	Хятад	Хятад
II байр	Хятад	Хятад	Хятад	ОХУ	ОХУ	ОХУ	АНУ	АНУ	АНУ	АНУ
III байр	Япон	Япон	Япон	БНСУ	Бусад	АНУ	Бусад	Бусад	Бусад	Бусад

Эх сурвалж: А.Цолмонгийн тооцоолсноор

Хөрш орнууд болон БНСУ-тай хийж буй худалдаа, эдийн засгийн харилцаагаа цаашид хадгалж хөгжүүлэхээс гадна улам өргөжүүлэх, шинэ чиглэлд хамтран ажиллах, ялангуяа гадаад худалдаа-зах зээлийн харилцааны өрөөсгөл бүтцийг өөрчилж боловсруулах

үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт давамгайлсан гадаад худалдааны ирээдүйтэй чиглэлийг хэтийн зорилгоо болгох нь Монгол улсын тогтвортой хөгжлийн тулгам чухал асуудал мөн.

Цаашид ДХБ-аар дамжуулан жижиг орны эрх ашгийг хамгааалуулах чиглэлээр илүү дэвшилттэй санал санаачлагыг гаргаж ажиллах хэрэгтэй болоод байна.

Зүүн Хойд Азийн бүс нутгийн худалдааны чөлөөт бүс ба Монголын оролцоо: Зах зээлийн нэгдмэл бодлогод шилжих нь

Зүүн Хойд Азийн орнууд зах зээлийн өрсөлдөөнд ямар түвшинд оролцож, хир зэрэг амжилтанд хүрэх сонирхолтой асуудал юм. Маш олон ажиглагчид Хятад, Хонконг, Тайвань, Япон, Өмнөд Солонгос зэрэг хүчирхэг улсуудыг нэгтгэсэн /Оросын алс дорнод, Монгол, Хойд Солонгос зэрэг улсууд гишүүнээр элсэх өндөр магадлалтай/ Зүүн Хойд Азийн Худалдааны Чөлөөт Бүсийг бий болно хэмээн үзэж байна.

Хэдийгээр бэрхшээлтэй асуудлууд байсаар байгаа ч Зүүн Хойд Азийн орнуудын хөгжилд хүрэх зам нь гагцхүү эдийн засгийн интеграци, нэгдэл гэдгийг энэ бүс нутгийн улсууд сайтар ойлгож эхэлсэн нь хөгжлийн чухал гараа юм.

Үүнийг интеграци хөгжлийн 6 үе шатны эхний 3 түвшинд авч үзэж болно. Өөрөөр хэлбэл бид энэ бүс нутагт эхний ээлжинд "Хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээрүүд", "Чөлөөт худалдааны гэрээ"-г бүс нутгийн улс орнуудын хооронд өргөн хүрээнд байгуулсны үндсэн дээр "Чөлөөт Худалдааны Бүс"-ийг бий болгох нь зүйтэй юм.

Хятад, Япон болон Солонгосын эдийн засгийн өсөлт сайн байх нь энэ бүс нутагт цаашид "Гаалийн Холбоо"-г байгуулах үндэс суурийг тавьж өгөх юм. Интеграци хөгжлийн дээрх үе шатуудыг амжилттай хэрэгжүүлэхэд улсуудын гааль, татварын бодлого тэр дундаа гаалийн тарифийн уян хатан бодлого хамгийн чухал юм.

Монгол улсын хувьд сонирхогч орнуудтай Чөлөөт Худалдааны Гэрээ байгуулж ажиллах, эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсүүдэд оролцох, түүнийг өөрийн улсад байгуулах нь ЗХА-ийн зах зээлд гарах ирээдүйтэй арга зам байх болно. Монгол улсын Засгийн Газраас энэ чиглэлд тодорхой ажлуудыг хийгээд эхэлчихсэн, Замын Үүдийн чөлөөт бүсэд гадаадын хөрөнгө оруулалтыг татах талаар бодит алхам хийгдээд байгаа билээ. Алтанбулагт худалдааны чөлөөт бүс байгуулах ажил эхлээд хэрэгжиж байна.

Зах зээлийн нэгдмэл бодлогын механизм: гаалийн тарифийн систем ба Монгол улсын экспортын боломж. ЗХА-ын бүс нутгийн гаалийн тарифийн системийн талаар судлах нь Монгол улсын эдгээр орнууд руу хийх экспортын бүтээгдэхүүний боломжийг тодруулж өгөх ач холбогдолтой юм.

Тарифийг ерөнхийд нь 3 түвшинд ангилж үзэн судалсан болно. Үүнд:

1. Тарифийн хэвийн түвшин
2. Улсаар болон зүйлээр ангилагдсан тарифийн дундаж түвшин
3. Тариф өндөртэй зүйл, хэсгүүд
4. Татваргүй бараа, зүйлс

Хамгийн өндөр тарифтай секторуудад хөдөө аж ахуй /загасны аж ахуйг тооцохгүй/, тээврийн хэрэгсэл, fiber болон хувцас, савхи, резин, гутал, аялалын хэрэгсэл зэрэг нь буурах дарааллаар тооцогддог байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж тарифийн хувьд Солонгос, Япон, Хятад улсууд хоёр оронтой тоонд байдаг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хамгийн өндөр тарифийг Солонгос, Япон хоёр эзэмшдэг. Тээврийн хэрэгслийн тарифийн түвшин Хятадад хэт өндөр байгаа юм.

Хятад улс дэлхийн худалдааны байгууллагад элсэхийн тулд 1998 онд 80-100% байсан автомашины тарифийн түвшнээ 2004 онд 34,2% болгож, 2006 оны 7 сарын 1-нд 25%-д хүргэх аж.

Манай улсын хувьд ЗХА-ын улсуудад экспортлох боломжтой бүтээгдэхүүн нь уул уурхайн гаралтай хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн, газрын тос, аж үйлдвэрийн зарим бүтээгдэхүүн болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл тарифийн түвшин нь өндөр байгаагийн улмаас манай улсын хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эдгээр орнуудын зах зээлд төдийлэн орон зай байхгүй байгаа нь харагдаж байна.

Харин ЗХА-ын өндөр орлоготой хүн амын бүлэгт зориулан Монголын экологийн цэвэр бүтээгдэхүүнийг гаалийн тарифийн хөнгөлөлттэй нөхцөлөөр /асуудлыг урьдчилан тавьж шийдвэрлүүсний дагуу / ЗХА-ын зах зээлд нэвтрүүлж болох юм.

Зүүн Хойд Азийн бүс нутаг дотроо Япон улс татваргүй барааны зүйлсээрээ давамгайлдаг. Японы хувьд дунджаар бүх барааны 40% нь татваргүй байдаг.

Манай улсын хувьд дээрх орнуудын татваргүй барааны жагсаалтанд хамаарагдах барааг эдгээр орны зах зээлд нийлүүлэх ойрын ирээдүйн чадамж нэн бага байна. Үүнийг Япон, Хятад, Өмнөт Солонгосын татваргүй барааны нэр төрөл, түүний хувь хэмжээний судалгаа харуулж байгаа юм.

Ерөнхийд нь дүгнэж үзвэл, тарифийг бууруулах гэсэн АРЕС, ДХБ зэргийн дахин дахин, удаан хугацааны туршид хичээсэн оролдлогыг үл харгалзан Зүүн Хойт Азийн орнуудад тарифийн түвшин харьцангуй өндөр хэвээр л байгаа юм. Энэ бүс нутаг дахь тарифийг бууруулах гэсэн байнгын оролдлого, хүчин чармайлт нь ирээдүйд Худалдааны Чөлөөт Бүс байгуулахыг зайлшгүй шаардаж буй юм.

Монгол улсын хувьд ДХБ-ын гишүүн улс тул тарифийн түвшин Чөлөөт бүсэд нэгдэхэд шаардлагатай түвшинд байж чадаж байгаа ба энэ талаар Засгийн Газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд үр дүнгээ өгч эхэлбэл ЗХА-ын чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах замаар гадаад худалдаагаа нэмэгдүүлж, эдийн засгаа хөгжүүлэх бүрэн боломжтой юм.

АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ

1. Н.Батнасан. Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөл байдалд хийсэн шинжилгээ. УБ.2005
2. Д. Дагвадорж. Маркетинг-зах зээлийг эзэмдэгч түлхүүр ухаан: Маркетинг, бизнес, хөгжил. УБ.2004
3. Dagvadorj D, New Asia and Mongolia. Research paper. Seoul 2001.
4. Dagvadorj. Business development and marketing capability of Mongolia. The Network of North-East Asia Economic Cooperation. Conference papers of Korea Mongolia Economic Association. Seoul. Korea. May 2001
5. Dagvadorj D, Market Situation and Opportunities in Mongolia. Journal of Business Administration. Volume 62. Bangkok. 1993.
6. Hawkins, Best, Coney. Consumer behavior: Building Marketing Strategy. Eighth Edition. Irvin McGraw – Hill higher Education. 2001. pp40-41
7. Political, Security, Economic and Infrastructure Factors of Economic Cooperation in the North East Asia. Ulaanbaatar, 2002
8. Thomas Tan Tsu Wee, In An exploration of a global teenage lifestyle in Asian societies, Journal of Consumer Marketing; 16:4 1999; pp365-375 argues.
9. Ten Years of Tumen River Area Development: Chan-Woo Lee. ERINA booklet. Volume 2 February 2003. BRIEFING PAPER. CUTS Centre for International trade, Economics & Environment. № 4. 2004

Websites:

WTO. <http://www.wto.org>
 World Bank <http://www.worldbank.org>
 International Monetary Fund <http://www.imf.org>
 UNDP <http://www.undp.org>
 Human Development Report Office UNDP <http://hdr.undp.org>
 Korea National Statistical Office, www.nso.go.kr/acces